



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн 15 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2022/22/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:
reakomaudit@gmail.com
Дархан-Уул аймаг
2022 он

Тэргүүлэх аудиторын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**
Утас: **7037-3089**
Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn
Ахлах аудитор: **С.Батцэцэг**
Утас: **7037-3089**
Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn
Аудитор: **А. Батболд**
Утас: **9906-9301**
Цахим хаяг: ayushbatbold4@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

ДАРХАН УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН 15
ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ С.ЭНХЦЭЦЭГ ТАНАА

2022.02.25 № 161
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 15 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



/Ш.МӨНХБАЯР

009030374

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	45,326,790.16	46,677,630.96
35	БАРАА МАТЕРИАЛ	45,326,790.16	46,677,630.96
35100	Түүхий эд материал	2,371,550.00	1,226,200.00
35130	Эм боох материал	2,371,550.00	1,226,200.00
35400	Хангамжийн материал	42,955,240.16	45,451,430.96
35410	Бичиг хэргийн материал	875,400.00	703,050.00
35420	Аж ахуйн материал	40,758,370.16	41,463,581.96
35450	Барилгын засварын материал	157,500.00	1,049,850.00
35460	Хүнсний материал	1,163,970.00	2,234,949.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,803,449,176.59	1,749,637,649.72
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,803,449,176.59	1,749,637,649.72
39200	Биет хөрөнгө	1,337,574,596.51	1,283,987,929.60
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,298,146,198.87	1,298,146,198.87
39202	Хуримтлагдсан элэгдэл	(85,085,501.27)	(127,360,822.19)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	40,417,201.00	37,145,900.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(16,591,013.73)	(20,112,307.05)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,362,223.00	22,872,420.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,278,731.19)	(13,116,638.02)
39214	Бусад үндсэн хөрөнгө	89,319,997.91	89,319,997.91
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,382,083.68)	(6,573,125.52)
39217	Ном	3,666,305.60	3,666,305.60
39300	Биет бус хөрөнгө	465,874,580.08	465,649,720.12
39301	Програм хангамж	1,819,200.00	1,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,144,619.92)	(674,579.88)
39303	Бусад биет бус хөрөнгө	465,200,000.00	465,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,848,775,966.75	1,796,315,280.68
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,848,775,966.75	1,796,315,280.68
51	Засгийн газрын хувь оролцоо	1,848,775,966.75	1,796,315,280.68
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	752,956,287.00	752,956,287.00
51200	Хуримтлагдсан үр дүн	(261,868,418.81)	(314,210,853.40)
51210	Өмнөх үеийн үр дүн	(226,928,618.54)	(261,750,167.33)
51220	Тайлант үеийн үр дүн	(34,939,800.27)	(52,460,686.07)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,357,688,098.56	1,357,569,847.08
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,848,775,966.75	1,796,315,280.68

Пийк-Ом Аудит ХХК

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	658,934,420.00	565,659,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	48,673,020.00	210,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	48,673,020.00	210,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	210,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	210,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	18,924,800.00	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	29,748,220.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	610,261,400.00	565,449,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	567,333,600.00	531,294,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	567,333,600.00	531,294,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	100,000.00	623,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	100,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	623,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,827,800.00	33,532,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,827,800.00	33,532,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	693,874,220.27	618,120,586.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	693,874,220.27	618,120,586.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	651,835,408.56	600,788,224.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	429,700,451.34	426,564,011.94
210101	Үндсэн цалин	336,181,825.34	283,705,221.94
210102	Нэмэгдэл	66,545,426.00	116,268,590.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	383,000.00	-
210104	Урамшуулал	26,590,200.00	26,590,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,728,300.00	57,587,825.10
210201	Тэтгэврийн даатгал	37,814,916.07	40,102,825.10
210202	Тэтгэмжийн даатгал	3,988,913.73	4,318,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,972,866.74	3,550,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	904,673.02	874,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,046,930.44	8,742,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,228,769.45	21,817,371.12
210301	Гэрэл, цахилгаан	1,598,768.70	1,106,246.92
210302	Түлш, халаалт	14,734,292.65	14,488,157.20
210303	Цэвэр, бохир ус	4,895,708.10	6,222,967.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,603,527.50	5,177,538.20
210401	Бичиг хэрэг	1,231,000.00	1,205,750.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	439,027.50	500,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,933,500.00	1,085,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	57,000.00
210408	Бараа материал акталсны зардал	-	2,329,288.20

2105	Нормативт зардал	36,598,488.00	25,542,101.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,430,700.00	905,350.00
210502	Хоол, хүнс	35,167,788.00	24,636,751.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,730,720.00	8,627,650.00
210604	Урсгал засвар	50,730,720.00	8,627,650.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	630,500.00	580,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	50,000.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	580,500.00	580,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,614,652.27	54,891,226.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	251,170.00	500,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	579,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,363,482.27	53,811,526.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,038,811.71	17,332,361.84
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	100,000.00	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	100,000.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	30.55	215,128.88
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	30.55	215,128.88
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	41,938,781.16	17,117,232.96
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,938,781.16	17,117,232.96
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(34,939,800.27)	(52,460,686.07)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(34,939,800.27)	(52,460,686.07)

Пийк-Ом Аудит ХХК

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	752,956,287.00	1,357,688,098.56	(226,928,618.54)	1,883,715,767.02
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	752,956,287.00	1,357,688,098.56	(226,928,618.54)	1,883,715,767.02
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(34,939,800.27)	(34,939,800.27)
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	752,956,287.00	1,357,688,098.56	(261,868,418.81)	1,848,775,966.75
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	752,956,287.00	1,357,688,098.56	(261,868,418.81)	1,848,775,966.75
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	118,251.48	118,251.48
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	752,956,287.00	1,357,688,098.56	(261,750,167.33)	1,848,894,218.23
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(118,251.48)	-	(118,251.48)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(52,460,686.07)	(52,460,686.07)
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	752,956,287.00	1,357,569,847.08	(314,210,853.40)	1,796,315,280.68

Пийк-Ом Аудит ХХК

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	610,261,400.00	565,659,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	210,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	210,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	210,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	210,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	610,261,400.00	565,449,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	567,333,600.00	531,294,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	567,333,600.00	531,294,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	100,000.00	623,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	100,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	623,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	42,827,800.00	33,532,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	42,827,800.00	33,532,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	610,261,400.00	565,659,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	610,261,400.00	565,659,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	568,222,588.29	548,327,538.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	429,700,451.34	426,757,937.04
210101	Үндсэн цалин	336,181,825.34	283,899,147.04
210102	Нэмэгдэл	66,545,426.00	116,268,590.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	383,000.00	0.00
210104	Урамшуулал	26,590,200.00	26,590,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	55,728,300.00	57,393,900.00
210201	Тэтгэврийн даатгал	37,614,819.74	39,908,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,071,380.26	4,318,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,352,100.00	3,550,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	880,900.00	874,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,809,100.00	8,742,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,228,769.45	21,817,371.12
210301	Гэрэл, цахилгаан	1,598,768.70	1,106,246.92
210302	Түлш, халаалт	14,734,292.65	14,488,157.20
210303	Цэвэр, бохир ус	4,895,708.10	6,222,967.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,934,427.50	2,020,500.00
210401	Бичиг хэрэг	150,000.00	450,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	439,027.50	500,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,981,500.00	765,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	363,900.00	305,000.00
2105	Нормативт зардал	33,686,970.00	26,556,730.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,836,700.00	0.00
210502	Хоол, хүнс	29,001,270.00	25,707,730.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	849,000.00	849,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,599,000.00	11,500,000.00

210604	Урсгал засвар	21,599,000.00	11,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	630,500.00	580,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	205,500.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	425,000.00	580,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	714,170.00	1,700,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	401,170.00	500,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	313,000.00	1,200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,038,811.71	17,332,361.84
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	100,000.00	0.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	100,000.00	0.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	30.55	215,128.88
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	30.55	215,128.88
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	41,938,781.16	17,117,232.96
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	41,938,781.16	17,117,232.96
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.00	0.00
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	0.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	0.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.00	0.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.00	0.00
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	0.00	0.00
240001	Гадаад зээлийн үндсэн төлбөр	0.00	0.00
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	0.00	0.00
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	0.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	572,541,100.00	547,494,538.16	25,046,561.84	95.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	572,541,100.00	547,494,538.16	25,046,561.84	95.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	572,541,100.00	547,494,538.16	25,046,561.84	95.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	437,129,300.00	426,757,937.04	10,371,362.96	97.63
210101	Үндсэн цалин	369,541,400.00	283,899,147.04	85,642,252.96	76.82
210102	Нэмэгдэл	40,997,700.00	116,268,590.00	(75,270,890.00)	283.60
210104	Урамшуулал	26,590,200.00	26,590,200.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	57,393,900.00	57,393,900.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	39,908,900.00	39,908,900.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,318,100.00	4,318,100.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,550,200.00	3,550,200.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	874,200.00	874,200.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,742,500.00	8,742,500.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,746,700.00	21,817,371.12	7,929,328.88	73.34
210301	Гэрэл, цахилгаан	2,532,700.00	1,106,246.92	1,426,453.08	43.68
210302	Түлш, халаалт	18,700,100.00	14,488,157.20	4,211,942.80	77.48
210303	Цэвэр, бохир ус	8,513,900.00	6,222,967.00	2,290,933.00	73.09
2104	Хангамж, бараа материалын зардал	1,553,300.00	1,187,500.00	365,800.00	76.45
210401	Бичиг хэрэг	240,000.00	240,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	500,000.00	500,000.00	-	100.00
210404	Ном, хэвлэл	101,700.00	0	101,700.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	406,600.00	142,500.00	264,100.00	35.05
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	305,000.00	305,000.00	-	100.00
2105	Нормативт зардал	32,935,400.00	26,556,730.00	6,378,670.00	80.63
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	203,300.00	0	203,300.00	0.00
210502	Хоол, хүнс	31,883,100.00	25,707,730.00	6,175,370.00	80.63
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	849,000.00	849,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,500,000.00	11,500,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	11,500,000.00	11,500,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	580,500.00	580,500.00	-	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	580,500.00	580,500.00	-	100.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,702,000.00	1,700,600.00	1,400.00	99.92
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	502,000.00	500,600.00	1,400.00	99.72
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,200,000.00	1,200,000.00	-	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	572,541,100.00	547,494,538.16	25,046,561.84	95.63
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	531,294,400.00	514,177,167.04	17,117,232.96	96.78
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	531,294,400.00	514,177,167.04	17,117,232.96	96.78
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	41,246,700.00	33,317,371.12	7,929,328.88	80.78
320001	Орон нутгийн төсвөөс	41,246,700.00	33,317,371.12	7,929,328.88	80.78
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	484	484	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	39	39	-	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	32	32	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	6	6	-	100.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	405	405	-	100.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	405	405	-	100.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	405	405	-	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	39	39	-	100.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	27	27	-	100.00

Пийк-Ом Аудит ХХК

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	833,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	833,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	833,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	0.00	833,000.00
210401	Бичиг хэрэг	0.00	210,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	623,000.00
2105	Нормативт зардал	0.00	0.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.00	0.00
210502	Хоол, хүнс	0.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	0.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	0.00
210602	Тавилга	0.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	0.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	0.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	0.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	833,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	833,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	623,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.00	210,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

Пийк-Ом Аудит ХХК

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн 15 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд цалингийн зардалтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор А. Мөнхцэцэг, аудитор А. Батболд гүйцэтгэж, чанарын хяналтыг “Пийк-Ом Аудит” ХХК-ны чанарын хяналтын менежер Б. Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн 15 дугаар цэцэрлэг 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк Ом Аудит ХХК-нд 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

15 дугаар цэцэрлэг нь хүүхдийн бие даан суралцах чадварыг хөгжүүлэх, сургалтын чанарт ахиц гарган, багшийн хөгжлийг дэмжиж, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд “Дархан-444” хөтөлбөрийн хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Цэцэрлэгийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус цэцэрлэгийн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж болон орон тоо байхгүй.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн 15 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 693,874.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,938.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4,857.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дархан-Уул аймгийн 15 дугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 52,460.7 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	45,326.7	46,677.6	1,350.8
Үндсэн хөрөнгө	1,803,449.2	1,749,637.6	(53,811.6)
Нийт хөрөнгө	1,848,775.9	1,796,315.2	(52,460.6)
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,848,775.9	1,796,315.2	(52,460.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,848,775.9	1,796,315.2	(52,460.6)

Бараа материал дансны үлдэгдэл 1,350.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд 39,846.7 мянган төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр, 210.0 мянган төгрөгийн бараа материалыг тендерийн орлогоос худалдан авч, 38,705.8 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны хувьд тайлант онд Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021 оны 12 сарын 31-ны өдрийн А/398 тоот захирамжаар элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 4,456.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө актлаж, 53,811.5 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаар оны эцэст 1,749,637.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,796,315.3 мянган төгрөг болж 52,460.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Тус цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 93,274.5 мянган төгрөгөөр буюу 14.1 хувиар буурсан нь орон нутгийн төсвийн санхүүжилт 9,295.3 мянга, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 36,039.2 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 48,673.0 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 75,753.6 мянган төгрөгөөр буюу 10.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан хоолны зардал 10,531.1 мянга, эд хогшил урсгал засварын зардал 42,103.1 мянган төгрөгийн зардлууд байна. Энэ нь өмнөх онд дулааны шугам сольсон, нэг ангийг тохижуулсантай холбоотойгоор урс гал засварын зардал буурсан, ковидын нөхцөл байдлын улмаас хөл хорио тогтоосноос хоолны зардал буурчээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар дахин үнэлгээний нэмэгдэлтэй хөрөнгийг акталснаас дахин үнэлгээний нэмэгдэл дансыг 118.2 мянган төгрөгөөр бууруулсан бичилт хийсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 985,487.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 313,969.7 мянган төгрөгөөр бууруулж, 671,517.8 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төсөлд цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 555,611.7 мянга, хоол хүнс норматив зардлыг 194,708.9 мянган төгрөгөөр төсөвлөсөн нь өнгөрсөн оны батлагдсан төсвөөс 233,689.7 мянга, тайлант оны батлагдсан төсвөөс 280,255.9 мянган төгрөгөөр тус тус өндөр байгаа нь тайлант жилд норматив хүүхдийн тоог тухайн цэцэрлэгт хамрагдах 405 хүүхдээр тооцоолон төсөвлөснөөс шалтгаалжээ

Төсвийн тодотголоор 572,541.1 мянган төгрөг болгож 98,976.7 мянган төгрөгөөр бууруулсан нь Боловсролын сайд болон Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны А/292 А/525 дугаар тушаалаар батлагдсан “Цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын цахим сургалтанд шилжсэнтэй холбоотой юм.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 572,541.1 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 531,294.4 мянга, орон нутгийн төсвөөс 41,246.7 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 531,294.4 мянга, орон нутгийн төсвөөс 33,532.5 мянга, нийт 564,826.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 547,494.5 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсвөөс 17,117.2 мянга, орон нутгийн төсвөөс 215.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 547,494.5 мянган төгрөг буюу 95.63 хувьтай байна. 2021 онд цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 10,371.3 мянга, тогтмол зардал 7,929.3 мянга, нормативт зардал 6,378.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна. Энэ нь батлагдсан орон тооноос 3 хүн дутуу ажилласан, дундаж хүүхдийн тоо өмнөх оноос 37 хувиар буурсантай холбоотой.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт санхүүжилтээр дээд шатны төсвийн захирагчаас 623.0 мянга, төндрийн орлого болох 210.0 мянга нийт 833.0 мянган төгрөг орж ирсэнээс бичиг хэрэгт 210.0 мянга, хог хаягдал зайлуулах, хортон шавьж устгахад 623.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

3.8 Аудитын гол асуудал

Дархан -Уул аймгийн 15 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох

журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын явцад шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд тайлант хугацаанд оруулбал зохиох 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 141 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцорсон 8 мэдээлэл байна. Мэдээлэл хоцорсон шалтгаан нь тухайн хугацаанд нягтлан бодогч Ж.Амаржаргал нь Ковид-19 цар тахлын халдварын улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, интернет орчинд ажиллах боломжгүй байсныг эрхлэгчийн 2022 оны 2 сарын 15-ны 08 дугаар албан бичгээр баталгаажуулсан.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар шилэн дансны цахим хуудсанд орлого, зарлагын мэдээллийг хуримтлуулан бөөн дүнгээр оруулсан байсан. Биелэлтийг 2021 оны 10 сарын 19-ны өдрийн 48 тоот албан бичигээр ирүүлсэн ба тайлагналын дараах үе шатанд дахин хянахад хэрэгжилт 100 хувьтай байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,527.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Цалингийн зардлын данстай холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт:

Эрхлэгчийн 2021 оны 12 дугаар сарын Б/29, Б/30 дугаар тушаалаар 17 багш, ажилтан нарт ур чадварын нэмэгдлийг олгохдоо шалгуур үзүүлэлтээр үнэлээгүй, байгууллагын хөдөлмөрийн аврага болон шилдэг ажилтанд ур чадварын нэмэгдэл болох 2,527.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 3 “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно”, Боловсрол, шинжлэх ухааны сайд, хөдөлмөр нийгмийн хамааллын сайд, сангийн сайдын хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” 2021 оны 02 дугаар сарын 01-ны А/35, А/10, 9 дүгээр тушаалын хавсралтын “Энэ шалгуур үзүүлэлтийн 3-д заасан нийтлэг шалгуурыг хангасан

цэцэрлэгийн багш ажилтаны ажлыг дараах тусгай шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Боловсрол, шинжлэх ухааны сайд, хөдөлмөр нийгмийн хамааллын сайд, сангийн сайдын хамтарсан “Шалгуур үзүүлэлт шинэчлэн батлах тухай” 2021 оны 02 сарын 1-ны А/35, А/10, 9 дугаар тушаалын хавсралтын дагуу шалгуур үзүүлэлтийг дүгнэх журамыг боловсуулж, мөрдөн ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дархан-Уул аймгийн 15 дугаар цэцэрлэг	1	2,527.4	-	-	-	-	1	0	1	2,527.4
	Дүн	1	2,527.4	0	0	0	0	1	0	1	2,527.4

ПИЙК-ОМ АУДИТ ХХК

2022.02.15